

# ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ БУЙ АЖЛУУД

**Илтгэгч:** Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын дарга О.Лхагвацэдэн



## БОДЛОГЫН ЗОРИЛГО

Салбарыг үндэсний нийгэм-эдийн засгийн хөгжилд тэргүүлэх оролцоо бүхий салбар болгон тогтвортой хөгжүүлэхэд оршино. Үүнд:

1. хууль, тогтоомжийн шинэ зохицуулалттай;
2. удирдлага, бүтэц зохион байгуулалтын оновчтой менежменттэй;
3. хүний хөгжил, мэдлэгт суурилсан;
4. хөрөнгө оруулалтын үр өгөөж сайжирч, дэвшилтэт техник, технологи нэвтэрсэн;
5. үнэ тарифын зохистой тогтолцоо үйлчилж, өрсөлдөх чадвар тогтвортой дээшилсэн;
6. ашиглалт, үйлчилгээний бие даасан чадамжтай;
7. бүх нийтээрээ орон сууц, ус хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцлөөр эрх тэгш хангагдсан байх нөхцлийг бүрдүүлсэн;
8. хүн ам, хот, суурины хөгжил, түүний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангасан байна.

## Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зорилтууд

### Орон сууцны талаар баримтлах зорилтын хүрээнд:

- ❖ орон сууцны газар өмчлөл, орон сууц төлөвлөх, барих, ашиглалт, үйлчилгээний талаар хууль эрх зүйн зохицуулалтын боловсруулан хэрэгжүүлэх, иргэд орон сууцаар өөрсдийгөө хангах нөхцөлийг бүрдүүлэх;
- ❖ орон сууцны талаар төрөөс хүлээсэн үүрэг, санхүүгийн ачааллыг хөнгөвчлөх, хувийн хэвшлийг бодлогоор дэмжих;
- ❖ орон сууц нь иргэн, гэр бүлийн орлогын хэмжээ, худалдан авах чадварт нийцсэн, ая тухтай, аюулгүй байдлыг хангасан байх;
- ❖ орон сууцны талаар төрөөс хүлээсэн үүрэг, санхүүгийн ачааллыг хөнгөвчлөх, хувийн хэвшлийг бодлогоор дэмжих, татан оролцуулах;
- ❖ үндэсний түвшинд төрийн албан хаагчид, залуу гэр бүлийг хямд өртөгтэй орон сууцаар санхүүжүүлэх нөхцөл бүрдүүлэх;
- ❖ орон сууцны хэтийн болон ойрын ирээдүйн эрэлт хэрэгцээг бүрэн тооцож тодорхойлсон байх;
- ❖ олон жил ашиглагдан хуучирсан, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах;
- ❖ гэр /захын/ хороолол дахь төрийн үйлчилгээний зөрүүтэй байдал, ялгааг багасгах;
- ❖ хот, суурин газрын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлэх.

## Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зорилтууд

### Ус хангамжийн талаар баримтлах зорилтын хүрээнд:

- ❖ Ундны усны эх үүсвэр, ус хангамжийн найдвартай, тасралтгүй, аюулгүй байдлыг хангах;
- ❖ усны хязгаарлагдмал нөөцөд тулгуурласан хандлага, түүнийг дэмжсэн зохицуулалт бий болгох;
- ❖ ус олзворлох, боловсруулах, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийг тоон системд бүрэн шилжүүлэх, нэгдсэн ухаалаг сүлжээг бий болгох;
- ❖ үйл ажиллагааны хэвийн, зохих түвшинг хангасан, бодит өртөгт тулгуурласан үнэ тарифийн тогтолцоог бий болгож, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах;
- ❖ ус хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний усны алдагдлыг бууруулах;
- ❖ ус хангамжийн хэрэглээ, тооцох механизмыг бүрэн тоолууржуулж, ухаалаг систем нэвтрүүлэх;
- ❖ Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах, түүний тэжээгдлийн мужийн тогтвортой байдлыг тэтгэх цогц арга хэмжээ авах;
- ❖ Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний усыг тусад нь төлөвлөх техникийн шийдлийг зураг төсөлд тусгах, хэрэгжүүлэх;

## Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зорилтууд

### Ариутгах татуургын талаар баримтлах зорилтын хүрээнд:

- ❖ хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Улаанбаатар хот, аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих, шинэчлэлт хийж дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хяналтыг сайжруулах;
- ❖ Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон, инновацид суурилсан, лаг, тунадас болон цэвэршүүлсэн усанд дахин боловсруулалт хийх, эргүүлэн ашиглах замаар бохир ус цэвэрлэх байгууламжийн үр ашгийг дээшлүүлэх, хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх;
- ❖ хот, суурин газрын орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний саарал усыг стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулах, үйлдвэрлэл технологийн болон ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах техникийн шийдлийг зураг төслөөр дамжуулан хэрэгжүүлэх;
- ❖ лаг усгүйжүүлэх, лагаас биомасс, хийн түлш гаргах, эрчим хүчний дотоод эх үүсвэрээ хангах, эдийн засаг, байгаль экологийн хувьд ээлтэй, ашиглалтын зардал бага, орчин үеийн техникийн шийдэлтэй бага хүч чадлын бохир ус цэвэрлэх байгууламж барих.

## Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах хөгжлийн бодлогыг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

### Нэгдүгээр үе шат /2018-2023 он/:

Салбарын тогтвортой хөгжлийн суурийг бий болгох үе.  
Үүнд:

- ❖ Хууль эрх зүйн зохицуулалт, бүтэц зохион байгуулалт, удирдлагын менежмент боловсронгуй болж шинэчлэгдэх;
- ❖ шинжлэх ухаанд үндэслэж, инновацид суурилсан, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлтийн бодлого тууштай хэрэгжих;
- ❖ санхүү, хөрөнгө оруулалтын үр өгөөж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үүссэн өр, төлбөрийн дарамтыг бууруулах.

### Хоёрдугаар үе шат /2023-2028 он/:

Салбарын тогтвортой хөгжлийг хангах үе.

- ❖ Салбарын санхүүгийн бие даасан чадавхи сайжирах;
- ❖ орон сууцны хангамж, нөхцөл, ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, хүртээмж нэмэгдэх;
- ❖ баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 90%- д хүрч, хүн амын 60%-аас доошгүй хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.



### Хүрэх үр дүн:

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Ногоон хөгжлийн бодлогын эхний шатны зорилтуудыг хангах суурь нөхцөл бүрдэж, төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжиж, салбарын хөгжил нийгэм-эдийн засгийн өсөлтийг хангахуйц ахисан түвшинд хүрсэн байна.

### Хүрэх үр дүн:

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Ногоон хөгжлийн бодлогын хоёрдахь шатны зорилтод хүрэх суурь нөхцөл бүрдэж, улс орны нийгэм-эдийн засгийн өсөлтийг хангахуйц тогтвортой түвшинд хүрсэн байна.

## Хуулийн зорилго:

Энэхүү хуулийн зорилго нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## Хуулийн бүтэц

- 1 • **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.** Нийтлэг үндэслэл
- 2 • **ХОЁРДУГААР БҮЛЭГ.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх
- 3 • **ГУРАВДУГААР БҮЛЭГ.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
- 4 • **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.** Техникийн нөхцөл, тусгай зөвшөөрөл
- 5 • **ТАВДУГААР БҮЛЭГ.** Хангагч хэрэглэгчийн харилцаа
- 6 • **ЗУРГААДУГААР БҮЛЭГ.** Ус хангамж, ариутгах татуургын барилга, байгууламж, шугам сүлжээний ашиглалт, өмчлөл
- 7 • **ДОЛДУГААР БҮЛЭГ.** Хяналт, хариуцлага

## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

### Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний дүн:

❖ *Хэрэгждээгүй, дутуу хэрэгждэг заалтууд:*

**4.1.1**-УХАТ-ын талаарх төрийн бодлогыг тодорхойлох, **7.1**-аймаг, нийслэлийн ИТХурал нутаг дэвсгэртээ УХАТ-ыг хөгжүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, **11.2-11.4**-техникийн нөхцөлд тавих шаардлагад шинээр баригдах барилга байгууламжийн зураг төсөлд саарал усыг дахин ашиглах шийдэл тусгах, **15.1.11**-хангагч нь үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлээ ЗохЗөвлөлийн баталсан хэмжээнд авах, **16.2**-хэрэглээг хязгаарлах заалт орон нутагт бүрэн хэрэгжихгүй байна, **17.2**- төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг Усны хуультай уялдуулан тогтоох, **17.1**-Онц чухал объектод хамаарах ус хан.-ийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна. **17.8.3**-Унд, ахуйн бус зориулалтаар ашиглах худаг цооног өрөмдөх заалт биелдэггүй, **17.8.4**-Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгох /Хамгийн их зөрчигддөг заалт/, **18.3**-Цэв/байг. нь цэвэрлэсэн усыг эргүүлэн ашиглах тон/төх-тэй байх, **18.5**- үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа ариутгах татуургын шугамд нийлүүлэх, технологийн хэрэглээнд эргүүлэн ашиглах, **18.6**- Улсын чанартай авто замын дагуу байрлах зорчигч үйлчилгээний болон шатахуун түгээх газар нь ариутгах татуургын шугам сүлжээ бүхий ариун цэврийн өрөөтэй байна. Энэ арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

❖ **Хуулийн 188 заалтын 30 гаруй хувийг шинэчлэх шаардлагатай тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан.**



## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

### Практик үндэслэл, шаардлага:

❖ **3 дугаар зүйл.** “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” болон зарим зүйл заалтыг “Усны тухай” хууль болон холбогдох хууль, тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдуулан тодорхойлох;

❖ **10-р бүлэг.** Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн чиг үүрэг хязгаарлагдмал байгаагаас зохицуулалтын олон зүйлүүд орхигдож байгаатай холбогдуулан чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт оруулах, Зөвлөлийн эрх үүргийг нарийвчлан тодорхойлох;

❖ **12 дугаар зүйл.** Тусгай зөвшөөрөл, түүний ангилалыг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль болон холбогдох хуультай уялдуулан өөрчлөх;

❖ Манай улс Дэлхийн банкны судалгаагаар бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлээгүй, бизнес эрхлэгчдийг хангалттай дэмждэггүй, хувийн хэвшлийнхэн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авах шат дамжлага, хүнд суртал ихтэй гэж дүгнэсэн байна/

❖ **17 дугаар зүйл.** “Ус хангамж, ариутгах татуурга” хэсэгт 10 мянгаас дээш хүн оршин суудаг төвлөрсөн хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг /цагдаа/ гүйцэтгэж, бусад нь энгийн харуул хамгаалалттай байх гэсэн саналыг хэлэлцэх;

❖ **23 дүгээр зүйл.** Хууль тогтоомжид зөрчигчид хүлээлгэх хариуцлагад нэмэлт, өөрчлөлт оруулах.

❖ Сүүлийн жилүүдэд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй барилга байгууламж барих, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, байгаль орчин, усны эх үүсвэрийг бохирдуулах зэрэг зөрчил газар авсан тул эдгээрээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах;

❖ Хот суурин газруудын бохир ус цэвэрлэх байгууламжийн техник, технологи хуучирч, ихэнх нь бохир усыг стандартын шаардлагын хэмжээнд хүртэл цэвэрлэлгүй, байгальд шууд хаяж, байгаль орчныг бохирдуулан, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Иймд цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдээд гарч буй хаягдал усыг дахин ашиглах, лагийн менежментийг боловсронгуй болгох, үйлдвэрээс гарч буй бохир усыг урьдчилан цэвэрлэсний дараа ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлэх, норм стандартыг боловсронгуй болгох чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

## Хуулийн төсөл батлагдсанаар гарах үр дүн:

Усны эх үүсвэр, усны чанарт төр, олон нийтийн зүгээс тавих хяналт сайжирч, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах, бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, хөрс, ус, агаарын бохирдлыг буурч, усны нөөц хомсдох сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах ач холбогдолтой.

**Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ:**

### ТАЙЛАНГУУД

#### **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЙЛАН**

МОНГОЛ УЛСЫН ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТОЙМ СУДАЛГАА

#### **ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

#### **ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ, СӨХЭЗБДӨЭХ-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА

#### **ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТӨСӨЛ**

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /2 ХУВИЛБАР/

#### **ХУУЛИЙН ТӨСӨЛ**

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ /1-Р ХУВИЛБАР/

### **Судалгааны ажлуудын нэгдсэн дүгнэлт**

- ❑ Дээрх судалгаануудаас үзэхэд, СӨХЭЗБНЗОСБДӨЭХ-ийн тухай хуулийг хүчингүй болгож, Орон сууцны тухай хуулийн нэг бүлэгт тусган, орон сууцны ашиглалт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрөлтөй, мэргэжлийн байгууллагын бүтцэд сууц өмчлөгчдийн эрх ашгийг хамгаалах орон тооны нэгжийг байгуулан ажиллуулах;
- ❑ Олон улсын жишигт нийцсэн, хууль зүйн болон практик шаардлагыг хангасан, хэрэгжихүйц, бусад хууль тогтоомжтой уялдсан Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах .



## Хуулийн зорилго:

Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилт нь орон сууцны бодлого, зохицуулалтыг оновчтой тодорхойлон, төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, зорилтот бүлгийг орон сууцаар хангах, түрээсийн орон сууцны бодлого хэрэгжүүлэх, орон сууцны барилгын ашиглалт, мэргэжлийн байгууллагын үүрэг оролцоо, орон сууц өмчлөгчийн эрх, үүргийг тодорхойлох болон холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

## Хуулийн бүтэц

- 1 • **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.** Нийтлэг үндэслэл
- 2 • **ХОЁРДУГААР БҮЛЭГ.** Орон сууцны талаарх төрийн байгууллагуудын эрх хэмжээ
- 3 • **ГУРАВДУГААР БҮЛЭГ.** Төрөөс орон сууцаар хангах бодлого, зохицуулалт
- 4 • **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.** Орон сууцны ашиглалт
- 5 • **ТАВДУГААР БҮЛЭГ.** Орон сууц өмчлөгчийн эрх, үүрэг
- 6 • **ЗУРГААДУГААР БҮЛЭГ.** Нийтийн зориулалттай түрээсийн орон сууц
- 7 • **ДОЛДУГААР БҮЛЭГ.** Орон сууцны салбарын мэргэжлийн байгууллага
- 8 • **НАЙМДУГААР БҮЛЭГ.** Орон сууцны мэдээллийн сан

## Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

### Хууль зүйн үндэслэл:

#### Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)

- “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” (16-р зүйлийн 2)

#### Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого

(УИХ-ын 1999 оны 25 дугаар тогтоол)

“Орон сууцны асуудал нь улсын хөгжил, нийгмийн амьдралын түвшинг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл энх, сайн сайхан амьдрах, үр бүтээлтэй хөдөлмөрлөх язгуур нөхцөл болохын хувьд Монгол Улсын төрийн бодлогын салшгүй нэг хэсэг юм”

#### Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл

(УИХ-ын 2017 оны 11-р тогтоол)

Хавсралтын 4.43-т “Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Барилга, хот байгуулалтын яам боловсруулах”

## Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

### Практик үндэслэл, шаардлага:


- 2018 оны 9 дүгээр сарын 25-ны байдлаар манай улсад 892,849 өрх байгаагаас 27.7 хувь нь буюу 246,512 өрх инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд 45 хувь нь гэрт, 0.5 хувь буюу 4,599 мянган өрх зориулалтын бус сууцанд оршин сууж байна;
- Төлбөрийн чадвар, хэрэгцээ, шаардлагад нийцсэн орон сууцны хүртээмж, зохицуулалтыг бий болгох;
- Орон сууцны тухай хуульд заасан зарим нэр томъёо, ойлголт бусад хуулийн нэр томъёо, ойлголттой зөрчилдөж байгааг уялдуулах;
- Орон сууцны тухай хуулийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын чиг үүрэг, эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлох;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт 2017 онд иргэдээс 1850 гомдол ирснээс хамгийн их буюу 31.6 хувийг барилга, орон сууц, сууц өмчлөгчдийн холбоонд хамаарах асуудал эзэлж байна. Мөн Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд 2017 онд сууц өмчлөгчдийн холбоонд хамаарах 467 өргөдөл ирсэн;
- Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөлтэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах, мэргэжлийн байгууллага, сууц өмчлөгчдийн холбооны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны хүрээ, эрх, үүргийг шинээр тодорхойлох.
- Нийслэлийн өмчит байгууллагуудын 80-аад хувь нь насжилт өндөр буюу 40 жилийн насжилттай шугам хоолой эзэлж байна. Орон сууцны зарим инженерийн шугам сүлжээг мэргэжлийн байгууллага бус СӨХ буюу иргэдэд хариуцуулсан нь алдаатай зохицуулалт болсон байгааг залруулж, оновчтой, зөв зохицуулалтыг бий болгох;




## Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

### Практик үндэслэл, шаардлага:

Төвлөрсөн ус, дулаан, цахилгаан хангамжийн одоогийн схем



Төвлөрсөн ус, дулаан, цахилгаан хангамжийн санал болгож буй схем





## Дагалдан гарах хуулийн төслүүд

### Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд:

- Иргэний хууль
- Газрын тухай,
- Эрчим хүчний тухай,
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Газрын тухай, Зөрчлийн тухай,
- Орон сууц хувьчлах тухай,
- Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай,
- Хот байгуулалтын тухай
- Зөрчлийн тухай,
- Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийг хүчингүй болгох
- Орон сууцны тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл



## “Орон сууц” үндэсний хөтөлбөр

### Зорилго:

Төв, суурин газарт амьдардаг өрхүүдийн дийлэнх олонхийг тэдний худалдан авах чадварт нь нийцсэн, орчин үеийн чанар, стандартын шаардлага хангасан, монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон, инженерийн бүрэн хангамжтай, ногоон барилгын шийдэл бүхий орон сууцаар хангах

### Хэрэгжих хугацаа: 5 жил

- I үе шат (2018-2019 он): Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хангахад чиглэсэн хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.
- II үе шат (2020-2023 он): Шинэчлэгдсэн хууль, эрх зүйн орчинд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг бүрдүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

### Хөтөлбөрийн зорилт:

1. Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
2. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай дэд бүтэц бүхий ногоон барилгын шийдэл бүхий амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.
3. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжинэ.
4. Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэг буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байнгын асаргаа шаардах хүүхдийг халамжилдаг эсхүл 0-18 насны 4 ба түүнээс олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон эцэг, эх, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцлийг эрс сайжруулна.

## Нэгдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1.1.иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад чиглэсэн санхүүжилтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- 3.1.2.түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, ашиглах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- 3.1.3.орон сууцны даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;
- 3.1.4.орон сууц ашиглагч байгууллагуудын бүтцийг оновчтой болгох;

## Хоёрдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.2.1.гэр хорооллын өмчилсэн эдэлбэр газрыг тухайн газрын эздийн шууд оролцоотойгоор дахин төлөвлөж, газрыг зүй зохистой ашиглах хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 3.2.2.төв, суурин газрын гэр хорооллыг суурин амьдралын нөхцөл, стандартыг бүрэн хангасан монгол дүр төрх бүхий сайжруулсан гэр, амины сууцны хороолол болгон хөгжүүлэх;
- 3.2.3.инженерийн хангамжийн гол шугам сүлжээ, барилга байгууламжийг барих ажлыг төр хариуцаж, санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэн орон сууц болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж барих нөхцөлийг бүрдүүлэх;
- 3.2.4.өндөр технологийн бие даасан дэд бүтцийг дэмжиж хөгжүүлэх, инженерийн хангамжид сэргээгдэх эрчим хүч, инженерийн төвлөрсөн ба бие даасан эх үүсвэрийг хослуулан хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх;

## Гуравдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.3.1.хот, суурин газрын хэт төвлөрлийг сааруулах, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дагуул, хаяа хот, тосгодыг жигд тэнцвэртэйгээр хөгжүүлж, иргэдийн орон сууцны хангамж, хүртээмжийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;
- 3.3.2.орон сууцны барилгын эрчим хүчний (цахилгаан болон дулааны) хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний хэрэглээг хэмнэлтийн тарифын бодлогоор дэмжих, тоолууржуулах замаар хэрэглээгээрээ төлдөг тогтолцоонд шилжих;
- 3.3.3.орон сууцны барилгыг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, холбогдох норм, дүрэм, стандартыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр инженер, техникийн ажилчдыг сургах, мэргэшүүлэх;
- 3.3.4.шинээр баригдах орон сууцны барилгын эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн хүчин чадлын тодорхой хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шийдвэрлэх;
- 3.3.5.ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарах, инженерийн хангамжид эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж, хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг бүх талаар дэмжих;
- 3.3.6.орон нутгийн засаг захиргаа, сууц өмчлөгчдийн оролцоотойгоор дулааны алдагдал ихтэй, угсармал орон сууцны барилгуудыг дулаалах, ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцны барилгуудыг буулган, шинээр барих төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- 3.3.7.эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны санхүүжилтийг дэмжих боломжит эх үүсвэрүүдийг судалж, нэвтрүүлэх;
- 3.3.8.циркуляр эдийн засаг (circular economy)-ийн загварт шилжих, орон сууцны барилгын хог, хаягдлын менежментийн шинэ тогтолцоог бий болгох;
- 3.3.9.орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд хүртээмжтэй ил, далд авто зогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх

### Хөтөлбөрийн санхүүжилт:

Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улс, орон нутгийн төсөв;

5.1.2. гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж;

5.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж, хөрөнгө оруулалт;

5.1.4. банк, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээл;

5.1.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

### Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт:

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга тухайн орон нутгийн орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

6.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэхүү хөтөлбөртэй нийцүүлэн тухайн орон нутгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг сайжруулахад чиглэсэн дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлж болно.

## Хөтөлбөр хэрэгжснээр гарах үр дүн

- 1.Төв, суурин газарт амьдардаг өрхүүдийн дийлэнх олонхи нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болсон байна.
- 2.Орон сууцны салбарын эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.
- 3.Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.
- 4.Түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.
- 5.Орон сууц ашиглагч байгууллагуудын оновчтой бүтэц бий болсон байна. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөх хүрээнд 70000 айлын амины орон сууц шинээр баригдаж, дэд бүтцийн 200 төв шинээр баригдана.
- 6.Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн 104800 өрх шинээр инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болсон байна.

## НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧИГ

- Бохир ус цэвэрлэх байгууламж. MNS EN 12255 цуврал стандартууд;
- 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. MNS EN 12566 : 2011 цуврал 5 стандарт;
- Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн нэр томьёо, тодорхойлолт-тайлбар толь MNS 6279 : 2011;
- Ахуйн бохир ус цэвэрлэх бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж” Давтан хэрэглэх зургийн цомог 1-Г2.907.9, 2-Г907.9”, 2012 он;
- Хоногт 100 м<sup>3</sup>, 150 м<sup>3</sup>, 250 м<sup>3</sup> бохир ус цэвэрлэх бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж НЗМ-2013/2084 нэг маягийн зургийн альбом;
- Хоногт 3000 м<sup>3</sup> ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зургийн зураг төсөл;
- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ. Ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал MNS ISO 24511 : 2012;
- Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага. MNS 6743 : 2018;

## БОЛОВСРУУЛЖ БУЙ НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛҮҮД

- “Цэвэршүүлсэн усыг усалгаанд ашиглах” ISO/CD 16075-1 багц стандарт;
- Хур борооны багц стандарт;
- Хонгилын систем БД;
- EN 12050-2 бохир усны өргөлтийн станц;
- EN 1085 : 2007 Цэвэрлэх байгууламжийн нэр томьёо;
- Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал;
- EN 16130:2013 Барилга, дэд бүтэц болон үйлдвэрийн барилга байгууламжийн инженерийн үйлчилгээ.



## АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА





## Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах хөгжлийн бодлогыг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

### Нэгдүгээр үе шат

/2018-2023 он/:

Салбарын тогтвортой хөгжлийн суурийг бий болгох үе.



1. томоохон хот, суурины ус хангамжийн үйлчилгээ тасралтгүй сайжирч, тогтвортой байдал хангагдсан байх;
2. Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд- ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх техникийн шийдлийг зураг төсөлд тусгах замаар хэрэгжүүлж эхлүүлсэн байх;
3. Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд- ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх техникийн шийдлийг зураг төсөлд тусгах замаар хэрэгжүүлж эхлүүлсэн байх;
4. усны хэрэглээ бүрэн тоолууржиж, усны хэмнэлттэй зарцуулалт бүх нийтийн түвшинд дадал, хэвшил болсон байх;
5. "Тайшир-Алтай" төслийг хэрэгжүүлж, Алтай хотын хүн амын эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээ нэмэгдсэн байх;
6. Улаанбаатар хотын бохир усны Төв цэвэрлэх байгууламжид орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурч, үнэргүй, орчны бохирдолгүй болон шинэчлэгдэж, технологийн үйл ажиллагаа нь жигдэрч эхэлсэн байх;
7. Дархан, Арвайхээр, Даланзадгад, Сайншанд, Цэцэрлэг хотуудад орчин үеийн техник, технологитой бохир ус цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор байгаль орчны тэнцвэрт байдал хангагдсан байх;
8. ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний насжилтийг уртасгах, шинэчлэх, засварлах ажилд шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байх.




## Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах хөгжлийн бодлогыг үндсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат

/2023-2028 он/:

Салбарын тогтвортой  
хөгжлийг хангах үе.



1. Улаанбаатар хотын хүн амын ус хангамжийг нэмэгдүүлэхэд дагуул голуудын урсацыг тэтгэх, гадаргын усыг хуримтлуулах, унд ахуйн хэрэгцээнд ашиглах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж эхэлсэн байх;
2. Улаанбаатар хотын бохир усны Төв цэвэрлэх байгууламж инновацид суурилсан технологитой, цэвэршүүлсэн усанд дахин боловсруулалт хийж үйлдвэрлэлийн зориулалтаар эргүүлэн ашиглах, лагийг бүрэн боловсруулж өөрийн эх үүсвэрээр эрчим хүчний дотоод хэрэглээгээ хангах, өртөг зардлаа бууруулах нөхцөл бүрдсэн байх;
3. Монгол орны цаг уурын нөхцөлд ашиглаж болохуйц лаг боловсруулах, дахин ашиглах, зайлуулах оновчтой арга, технологийг сонгож хэрэгжүүлсэн, байгаль орчны тэнцвэртэй байдал хадгалагдсан байх;
4. Хот, суурины нийтийн аж ахуйн байгууллагуудын усны хяналт-шинжилгээний лаборатори хими, бактериологи зэрэг нарийн шинжилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаж шинэчлэгдэнэ.

## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

- ❑ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь анх 2002 оны 06 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан. /6 бүлэг, 19 зүйл, 128 заалт/
- ❑ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2011 оны 10 дугаар сарын 06-нд батлагдсан. /7 бүлэг, 24 зүйл, 188 заалт/

### ***Хуулийн зорилго, зохицуулах харилцаа:***

Энэхүү хуулийн зорилго нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### ***Хуулийн шинэчилсэн найруулгад нэмж тусгасан зүйлүүд:***

- **Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийг** байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, түүний бүрэн эрх, зохион байгуулалт, чиг үүргийг хуульчилсан.
- Нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрлийг нарийвчлан заасан.
- Үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх, технологийн хэрэгцээндээ эргүүлэн ашиглах зохицуулалтыг тусгасан.
- Улсын чанартай авто замын дагуу байрлах зорчигч үйлчилгээний болон шатахуун түгээх газар нь ариутгах татуургын шугам сүлжээ бүхий ариун цэврийн өрөөтэй байхаар тусгасан.

## Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр НАА-н байгууллагуудаас ирүүлсэн санал. /2016-2017/

№	Хуулийн зүйл, заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулах санал	Санал ирүүлсэн аймгууд
1.	3.1.19. “Саарал ус” гэж ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг,	3.1.19. “Саарал ус” гэж ахуйн хэрэглээнээс гарсан ямар нэгэн ялгадасгүй ахуйн бохирдолтой усыг, гэх мэт <b>хуулийн нэр томъёоны хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах,</b>	Орхон, Ховд, УБ хотын ЗАА, УСУГ.
2.	7 ба 8 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн ИТХурал, ЗДаргын бүрэн эрх.	7 ба 8 дугаар зүйлд аймаг, нийслэл, <b>сум, дүүргийн</b> ИТХ, ЗДаргын эрх үүргийг нарийвчлан тодорхой тусгах.	Дорноговь, Дорнод, Орхон, УБ хотын ЗАА
3.	9 ба 10 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөлийн бүтэц, бүрэн эрх.	9 ба 10 дугаар зүйл. <b>Усны үйлчилгээг зохицуулах хороо</b> гэх. Мөн хорооны эрх, үүрэгт тариф тооцох аргачлал, журам, хангагч, хэрэглэгчийн хоорондын төлбөр тооцооны журам, шугам сүлжээний элэгдэл хорогдол болон нормт алдагдлыг тооцох журам зэргийг боловсруулж батлах.	Завхан, УБ хотын ЗАА.
4.	17.2. Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх бөгөөд тэдгээрийн дэглэмийг Усны тухай хуулийн 31.3, 31.4-т заасны дагуу тогтооно.	Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх бөгөөд тэдгээрийн дэглэмийг <b>Усны тухай хуулийн 22.3, 22.4-т</b> заасны дагуу тогтооно. гэх. <b>Усны хуультай уялдуулах.</b>	Орхон, Ховд, УБ хотын ЗАА, УСУГ.
5.	17.1. Онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг Дотоодын цэргийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2.1-д заасны дагуу дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна.	10 мянгаас дээш хүн оршин суудаг төвлөрсөн хот суурины ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг /цагдаа/ гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна гэж өөрчлөх,	Өвөрхангай, бусад аймгууд мөн энэ саналыг хэлдэг
6.	21 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн биелэлт, түүнд тавих хяналт.	Хот, суурин газрын ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд айл өрх бууж, барилга байгууламж барих, аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж ундны усны эх үүсвэрийг бохирдуулах зөрчил их гардаг тул хариуцлагыг чангатгах,	Архангай, Дорноговь, Говь-Алтай, Дархан, Завхан, Нийслэлийн ЗАА, УСУГ.
7.	14, 15, 18 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг, үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох, Цэвэрлэх байгууламж.	Хангагч, хэрэглэгчийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, цэвэрлэх байгууламжаас гарах лагийг боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах, гэх мэт.	Нийслэлийн ЗАА, УСУГ,



## Хуулийн бүтэц

### Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

- Нийтлэг үндэслэлийг тодорхойлох энэхүү бүлэгт хуулийн зорилт, зарчим, хамрах хүрээ, нэр томъёоны асуудлыг тусгана. Хуулийн төсөлд орон сууцны төрөл, түрээсийн орон сууц, мэргэжлийн байгууллага, сууц өмчлөгч, сууц өмчлөгчид ногдох хэсэг, дангаар болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөтэй холбоотой шинэ нэр томъёоллыг тодорхойлно;

### Хоёрдугаар бүлэг. Орон сууцны талаарх төрийн байгууллагуудын эрх хэмжээ

- Улсын Их Хурлын бүрэн эрх
- Засгийн газрын бүрэн эрх
- Орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв /төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх (яам, сайд, агентлаг)
- Холбогдох бусад яамдын бүрэн эрх, чиг үүрэг
- Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх, хотын захирагчийн бүрэн эрх

### Гуравдугаар бүлэг. Төрөөс орон сууцаар хангах бодлого, зохицуулалт

Энэ бүлэгт зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулах чиглэлээр төрийн бодлогыг хэрэгжүүлэх институтийн тогтолцоо, байгууллагын үйл ажиллагааны чиглэл, эрх, үүргийг тодорхойлж, тус байгууллага нь зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулах санг удирдахаар тусгана;



### **Дөрөвдүгээр бүлэг. Орон сууцны ашиглалт**

орон сууцны барилга, түүний хийц бүтээц, инженерийн шугам сүлжээний их болон урсгал засвар хийх, сэргээн засварлах, шинэчлэх, орон сууцны орчны газрын ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг норм, нормативын дагуу тогтмол хийж гүйцэтгэх, ашиглалтын хэвийн байдлыг хангах, эдэлгээний хугацааг уртасгах менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хуульчилснаар хуулийн нэгдмэл орчинг бүрдүүлнэ;

### **Тавдугаар бүлэг. Орон сууц өмчлөгчийн эрх, үүрэг**

Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтын хэвийн байдлыг хангахтай холбоотой сууц өмчлөгчийн эрх, үүрэг, сууц өмчлөгчдийн эрх ашгийг төлөөлөх этгээдийн эрх зүйн зохицуулалтыг тусгана;

### **Зургаадугаар бүлэг. Нийтийн зориулалттай түрээсийн орон сууц**

санхүүжилт, түрээсийн орон сууцыг ашиглах, эзэмшихэд тавигдах шаардлага, түрээслэгч, түрээслүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага, түрээсийн төлбөртэй холбогдсон харилцааг тусгана;

### **Долоодугаар бүлэг. Орон сууцны салбарын мэргэжлийн байгууллага**

тус бүлэгт орон сууцны салбарын ашиглалтын асуудал хариуцах мэргэжлийн байгууллага, түүний эрх зүйн байдал, чиг үүргийг тусгана. Түүнчлэн, Сууц өмчлөгчдийн холбоонд хамаарах орон сууцны ашиглалттай холбоотой зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр зохицуулна;

### **Наймдугаар бүлэг. Орон сууцны мэдээллийн сан**

Мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой асуудал, орон сууцны бодлого, зохицуулалтын хүрээнд гомдол гаргах, хяналт тавих болон маргаан шийдвэрлэх журам, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгана.